



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 427

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 1,009,334,460.00 /нэг тэрбум есөн сая гурван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун жаран/ төгрөгийн үнэ бүхий Гэр, бүл, хүүхэд, ахмадын соёл, амралтын цогцолборын барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газрын дарга нарт тус тус дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
487 дугаар тогтоолын хавсралт

Нийслэлийн өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар	Ашиглагч байгууллага	Гүйцэтгэгчийн нэр
1	Гэр, бул, хүүхэд, ахмадын соёл, амралтын цогцолборын барилга байгууламж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	3 давхар, зооргүй, 648 м2	1,009,334,460.00	2019-12-19 2019/901	Чингэлтэй дүүргийн Гэр бул, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	"Их наяд хөгжил" ХК